

9

ХЯТАД, МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨТГӨХ АРГА ЗАМ

Э. Наран

Агуулгын товч

Хятад, Монгол хоёр улс хамтран монгол улсын уул уурхайн нөөц баялагийг нээн хөгжүүлэх нь хоёр улсын эрэлт шаардлагатай нийцэж, хоёр улсын эдийн засгийн харилцааг өргөтгөх хамгийн үр ашигтай арга зам болно. Мөн тэр нь XXI зууны хоёр улсын эдийн засаг худалдааны гол чиглүүлэг болох юм.

Нэг. Монголын уул уурхайн нөөц баялагийн байдал

Монгол улс бол Хятадын умартын чухал хөрш орон. Хоёр орон хэдэн мянган км урт хилийн шугамтай, өнө эртнээс харилцан ирсэн түүхтэй. Монгол бол газар нутаг уудам, байгалийн нөөц баялаг элбэг баян улс юм. Одоо газрын хэвлийд нь 80 гаруй төрлийн ашигт малтмал байгаа ба 3000 гаруй орд газрыг илрүүлээд байна. Уул уурхайн гол гол ашигт малтмалын тархалт, хэмжээ, нөөцийн тойм байдал гэвэл:

† **Нүүрс** бол Монголдоо элбэг ашигт малтмалын нэг, тус улсын бүх аймагт нүүрс бий. Түүнээс зүүн хэсгийн нүүрсний чанар сайн, нөөц их, нүүрсний давхарга зузаан, Монгол улс одоо 250 нүүрсний орд илрүүлээд байгаагаас геологийн нөөц нь 152 тэрбум тонн юм. Энэ хэдэн жилд гол 17 уурхайн нүүрс гаргалтын нийт хэмжээ 1000 тонноос доош байсан нь үйлдвэрийн бодит хүчин чадлаасаа хол доогуур байна.

† **Нефть.** Монгол улс 90-ээд оны эхнээс 20 гаруй жил зогссон нефть эрж хайх, ашиглах ажлыг сэргээлээ. Монголын нефть гол төлөв өмнө, зүүн зүгийн аймгуудад байдаг. Барагцаалсан тооцоогоор нефтийн нөөц 6-8 тэрбум баррель (түүний дотор 70 хувийн нефтийн бүтэцтэй бүс хараахан олдоогүй байна) байгаа нь зөвхөн Хятадтай хил залгаа дорнод, өмнө, баруун бүс нутагт нефть бүхий

харьцангуй том 13 газар байгаа ба нөөц нь 3 тэрбум баррелиас их юм. Улмаар нефтийн чанар сайн, түүний дотор API аяндаа оргилдог нь 40 гаруй бөгөөд Арабын улсуудын үйлдвэрлэж буй түүхий нефтьтэй адил болно. "Монгол улсын XXI зууны хөгжлийн программ"-д зааснаар тус улс 2000 оноос эхлэн жилд 200-400 мянган баррель түүхий нефть үйлдвэрлэх ба 2005-2010 онд жилийн үйлдвэрлэл нь 4,5-30 сая баррель, 2020 онд 62 сая баррель хүрэх юм. Сүүлийн хэдэн жилд Монголын нэг жилийн нефтийн хэрэглээний хэмжээ бараг 400-600 мянган тоннд хүрч, импортын 20-30 хувийг эзлэх болов. Голлон Оросын Омск, Ачинск, Ангарск гурван хотоос импортлож байна. Монгол улс түүхий нефтээ Хятадын нефтийн бүтээгдэхүүнээр солилцохыг хүсэж байна.

- **Зэс.** Монгол улс зэсийн нөөцөөр баялаг, зэрэглэл өндөр, одоо илрээд буй нөөц 240 сая тонн байна. Гол тархсан газар нь Хойт хэсгийн Хөвсгөл нуурын орчим, төв хэсэгт, Хангайн бүс нутаг, Орхон, Булган, Өмнөговь аймаг болно. Орхон аймгийн Эрдэнэтийн зэс молибдений үйлдвэр дэлхийн 10 том зэсийн үйлдвэрийн нэг бөгөөд Азидаа хамгийн томд орно. 65 жил ашиглаж болох бөгөөд одоо жилд 24 сая т зэсийн хүдэр, 400 мянган т зэсийн баяжмал үйлдвэрлэн гаргаж байна. Тус үйлдвэр Монголын валютын хамгийн том эх үүсвэр төдийгүй экспортын нийт дүнгийн 50 хувийг эзэлж, улсын санхүүгийн орлогод маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөр нэг мэдээгээр, Монголын Өмнөговь аймгийн Оюу-Толгойд асар их нөөцтэй зэсийн орд газар байгаа ба Монгол улс одоо дэлхийд нэртэй "ВНВ" компанитай хамтран үүнийг ашиглахаар бэлтгэж байна. Хэрвээ энэ уурхай ашиглалтанд орвол үйлдвэрлэлийн хүчин чадал нь Эрдэнэтийн зэс молибдений үйлдвэрлэлээс 2-3 дахин их байх болно.
- **Алт.** Монгол улс алтны тархац их. Нөөц баян. Одоогоор илрээд буй 130 гаруй алтны уурхайн геологийн нөөц нь 3000 т, нээж илрүүлсэн хэмжээ нь 160 т. Гол тархсан газар Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл, Төв, Булган, Баянхонгор зэрэг аймаг байна. Монгол улс 90-ээд оны эхнээс "Алт хөтөлбөр" хэрэгжүүлж эхэлсэнээс хойш 5 жилд (1992-1996) нийтдээ 13.136 т алт олборлосон нь өмнөх 70 жилийн олборлолтоос илүү байна. Монгол улс "Алт" хөтөлбөрийг улам гүнзгийрүүлэн боловсронгуй, оновчтой болгосон "Алт-2000" хөтөлбөрийг 2000 оны хавар боловсрууллаа. Энэ хөтөлбөрт тусгаснаар улсын хэмжээний алт олборлолтыг 1997 онд 6.9 т, 1998 онд 9.9 т, 1999 онд 14.8 т, 2000 онд 17 т хүрэхээр тооцсон байна¹. Одоогоор Монголд алт олборлон ашиглаж буй дотоод гадаадын хамтарсан ба бие даасан компани 100 давж, үйлдвэрлэлийн хэмжээ их нэмэгдэж 1998 оны үйлдвэрлэлийг 1990 онтой харьцуулахад бараг арван хэдэн дахин нэмэгджээ. 2000 оны эхний 10 сард Монголын алт олборлогч 100 аж ахуйн нэгж Монгол банкинд 11470, 7 кг алт (11 т гаруй) худалдсан нь өнгөрсөн оныхоос 17,2 хувь өсчээ. Мөн оны 9-р сар гэхэд л үйлдвэрлэл ба борлуулалт 1725,9 кг болжээ². Хэрвээ техник тоног төхөөрөмжөө сайжруулвал Монголын шороон алт үйлдвэрлэл жилд 50 т-д хүрч чадна. Монголын алт зөвхөн зэсийн дараа орох улсын чухал стратегийн бүтээгдэхүүн боллоо. 1999 онд алт экспортлолтын хэмжээ 117 сая ам. долларт хүрэв.

- **Хайлуур жонш.** бол нэгэн төрлийн нэн чухал стратегийн ашигт малтмал юм. Энэ нь цэргийн аж үйлдвэрт чухал түүхий эд болох төдийгүй шинэ, дээд зэргийн технологи букуу фторт химийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болдог, бас төмөрлөгийн аж үйлдвэрт зайлшгүй хэрэглэгддэг хайлуулагч шингэн болдог. Дэлхийд ховор бөгөөд дахин үйлдвэрлэж болдоггүй ашигт малтмал юм. Одоо бүх дэлхийн хайлуур жоншны цэвэр (100% CaF₂) нөөц 560 сая т байна³. Монголын хайлуур жоншны гол тархалт Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дорноговь аймгийн Хар айраг, Дундговь аймгийн Тарина уул бөгөөд олдоод байгаа 60 орд газрын нөөцийн хэмжээ нь 30 сая тонноос дээш, жилийн дундаж үйлдвэрлэл 860 мянган т, жилд 150 мянган т-оос дээш т-ыг экспортлох юм. Монгол бол дэлхий дээрх хайлуур жонш олборлодог гол орны нэг, үйлдвэрлэлийн хэмжээ нь Хятад, Мексикийн дараа дэлхийд 3-рт орно⁴. Орос ба тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн улс орнууд хайлуур жоншны гол хэрэгцээгээ Монголоос импортлож хангадаг.

- **Фосфор.** Монгол улсын фосфорын илэрсэн нөөц 1,4 тэрбум гаруй т бөгөөд дэлхийд 5-р байранд ордог. Фосфор бол Монголд зэс, алт, хайлуур жоншны дараа орох, шинээр өсөж буй нэг төрлийн экспортын гол түүхий эд юм. 1998 онд Монгол улс нь Орос, Хятад, Шинэ Зеланд, Малайз зэрэг улстай 1 т азотын бордоог 90 ам.доллараар, 1 т фосфорын нунтагийг 30 ам.доллараар экспортлох талаар хэлэлцэн тогтсон юм. Одоо Монгол улс фосфорын бордоо үйлдвэрлэж эхлээд байгаа бөгөөд хэрвээ жилд 150 мянган т фосфорын бордоо үйлдвэрлэж, экспортловол жилдээ 13,5 сая доллар олж чадах юм. Монголын хойт зүгийн Хөвсгөлийн уулсаас баруун тийш, урт нь хэдэн зуун км, өргөн нь 100 шахам км бүс газарт харьцангуй том талбайд фосфорын уурхай байдаг. Бүр 80-аад оны эхээр хуучин ЗХУ хайгуул хийж 40-100 жил ашиглаж болохыг тооцсон ба илрээд байгаа нөөц нь 200 сая т-оос дээш юм.

- **Төмөр** бол гол төлөв Хэнтийн уулс, Алтайн нуруу, Хөвсгөл нуурын орчим ба Сэлэнгэ мөрний дунд, доод сав газарт тархсан. Илрээд буй нөөц нь 2 тэрбум тонн. Монгол, Япон, Орос 3 улсын хамтарсан Дарханы төмөрлөгийн үйлдвэр бол Монголын түүхэнд анхных бөгөөд 1994 оны 7-р сард ашиглалтанд орсон, жилд 100 мян.т ган үйлдвэрлэж, гол нь Японд экспортлож байна. 2000 оны эхний хагас жилд үйлдвэрлэл, борлуулалт 5500 т байв.

- **Уран** (цөмийн шатах материал). Анхны хайгуулын урьдчилсан тооцоогоор Монголын ураны нөөцийн хэмжээ 1,4 сая т, дэлхийн ураны нөөцийн 23 хувийг эзэлдэг. Дэлхийд эхний арван байранд ордог. Бүр 70-аад онд ЗХУ Дорнод аймагт эрэл хайгуул хийж, Дорнод, Мардай, Нөмрөг, Гурван булаг зэрэг 6 газар ураны уурхай, мөн 100 гаруй орд газар илрүүлжээ. 1982 онд ЗХУ-ын тусламжаар жилд 2 сая т ураны хүдэр үйлдвэрлэх ураны үйлдвэр байгуулж, 1989-1995 онд олборлосон хүдрээ төмөр замаар дамжуулан Читагийн тойргийн Краснокаменск хотын уул уурхайн химийн үйлдвэрт борлуулалт хийдэг. 1995 онд Орос, Америк зэрэг улс оролцон "Төв Азийн уран" компани байгуулагдав. Тус компани Оросын

орхиж яваад үйлдвэрлэл нь зогссон Мардайн уурхайг сэргээж ашиглах гэсэн боловч ажилд ахиц гарсангүй. Дэлхийн цөмийн эрчим хүчний хэрэгцээ өссөөр байгаа тул Монгол улс элбэг баян ураны нөөцийг чухалчлан үзэж ашиглаж чадна гэж итгэж байна.

Үүнээс гадна, Монгол улсад бас мөнгө, хар тугалга, хром, мангаан, молибден, гянт болд, кали, алмаз, болор, давс, шөрмөсөн чулуу зэрэг төрөл бүрийн барилгын материал бий. Монгол улс эдгээр баялаг ашигт малтмалаа өнөөг хүртэл их хэмжээгээр эрж, нээн ашиглаагүй буюу үндсэндээ огт ашиглаагүй байна.

Хоёр. Хятадын уул уурхайн нөөц баялагийн тойм байдал

Хятад улс болбоос ашигт малтмалын том орон. 1999 оны 9-р сарын эхээр Аньхуй мужийн Тунлинд хуралдсан "Хятадын байгалийн баялаг бүхий хотыг хөгжүүлэх, цаашдын хөгжлийн асуудлыг судлах хурал"-ын мэдээгээр, Хятад улс одоо зөвхөн АНУ-ын дараахь дэлхийн хоёрдогч том уул уурхайн орон болжээ. Хятадын уурхайн нөөц баялагийн нэр төрөл олон, нийт хэмжээ баян, нээн ашиглах цар хүрээ их, үйлдвэрлэлийн хэмжээ өндөр юм.

Одоо Хятадад 168 төрлийн уурхай илрээд байгаагийн дотор 151-ийнх нь нөөцийг тогтоогоод байна. Илрээд буй 200 мянга орчим орд газар байгаа ба эрж хайх, нээж ашиглах уурхайн район 15 мянга орчим байна. Хятадын улс ардын аж ахуйд нэлээд чухал байр суурь эзэлдэг 45 төрлийн ашигт малтмалын үйлдвэрлэлийн нөөц хэмжээгээр дэлхийд 3-р байр эзлэж буй нь зөвхөн Орос, Америкийн дараа орж байна. Түүний дотор 10 гаруй төрлийн (ховор шороо, титан, молибден, гянт болд, цагаан тугалга, гөлтгөнө, хүнд жонш) ашигт малтмалын гаргалтын нэг хүнд ноогдох хэмжээ дэлхийн түвшингээс давжээ. Ийнхүү Хятадын ашигт малтмалын нөөц, нэр төрлийг авч үзвэл, үнэндээ баялаг ихтэй том гүрэн юм.

Хэдий тийм ч Хятадын ашигт малтмалын нэг хүнд ноогдох хэмжээ тун бага, тархац жигд бусыг тооцох хэрэгтэй. Улс ардын аж ахуйд чухал ач холбогдолтой (алт, мөнгө, зэс, хар тугалга, төмөр, мангаан, молибден, никель, уран, бор, алмаз, цагаан алт, хром, калийн давс, газрын тос, байгалын хий, байгалийн шүү гэх мэт) 16 төрлийн ашигт малтмалын илрүүлээд байгаа нөөц илт хүрэлцээгүй байна. Хятадын нэг хүнд ноогдох уурхайн баялагийн хэмжээ дэлхийн түвшингийн талд хүрэхгүй байгаа дэлхийд 80-р байр эзлэх юм. Энэ нь Хятадын аж ахуйн хөгжлийн шаардлагатай зохицохгүй байна. Хятадын уурхайн нөөц, хүн амын өсөлт хийгээд эдийн засгийн өсөлтийн хоорондын зөрчил удаан хугацаанд байсаар байх болно. Энэ бол хайхрахгүй байж болшгүй чухал асуудал юм.

Гурав. Хоёр талын уурхайн баялагийн харьцуулага

Ингээд дээр дурьдсаныг харьцуулан үзэхэд Монголд элбэг байгаа ашигт малтмалын нөөц баялаг гэвэл: нефть, байгалийн хий, алт, мөнгө, зэс эдгээр нь Хятадад бол ихээхэн дутагдалтай бөгөөд ялангуяа нефтийн баялагаар Хятад өөрийн хэрэгцээг хангахад бэрх юм. Хэдийгээр Хятад улс нефть гаргалтаар дэлхийд 5-рт, эрчим хүч үйлдвэрлэлтээр 3-рт ордог орон боловч, эрчим хүч зарцуулалтаар 2-рт ордог⁵. 1993 оноос Хятад улс нефть импортлогч орон болж, 1996 онд 160 сая баррель нефть, 1999 онд 40 сая тонн (бараг 200 сая баррель) нефть импортлосон ба урьдчилсан байдлаар 2000 онд 50 сая тоннд хүрэх ба цаашид нефтийн импорт аажмаар өсөх болно. Урьдчилсан тооцоогоор 2010 он гэхэд импортын нефть 100 сая т-аас давах ба Хятад улс нефтийнхээ хэрэгцээний 38 хувийг импортоор хангана гэж холбогдох мэргэжилтнүүд үзэж байна. Калийн давс, хром, алмаз, молибдений төрлийн өнгөт металлаар Хятад улс өнөөгийн үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа ба хэтийн төлөв муутай, нэн ховор ашигт малтмал юм. Төмөр, мангаан, хөнгөн цагаан, хар тугалга, химийн бордоо нь хэдийгээр өнөө үед Хятадад нийгэм-эдийн засгийн хөгжилд үндсэндээ баталгаатай ч хэрэгцээ шаардлагаа бүрэн хангаж чадахгүй, цаашид ч хангах баталгаа үгүй байна. Ялангуяа, фосфор, Хятадын фосфорын уурхайн баялаг дийлэнхийдээ өмнө зүгийн Юньнань, Гуйжоугийн өндөрлөг бүс нутаг болон Хубэй, Хунань, Сычуань-д төвлөрсөн ба дээр нь нээж ашиглахад ашиггүй нэлээд хүчин зүйлс бий бөгөөд хойт зүгт фосфорын бордоо асар их дутагдалтай хөрс шороог (Хятадын фосфорын бордоо асар их дутагддаг нийт талбайн 40 хувь) бордоогоор хангах нь хэцүү юм.

Чухам эндээс Хятад, Монгол хоёр орон уул уурхайн баялагаа нээж ашиглах талаар өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа явуулах бололцоог харж болно.

Дөрөв. Монгол улс гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулж олборлох үйлдвэрлэлээ хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж буй

Одоо, Монголын олборлох үйлдвэрлэлийн өртөг, улсын дотоодын нийт үйлдвэрлэлийн өртөгийн 20 хувийг эзлэж, уул уурхайн экспорт, нийт экспортын 50 хувиас дээш болж, боловсруулах үйлдвэр Монголын эдийн засагт шийдвэрлэгч ач холбогдолтой байна. Гэвч Монгол улсын хүч сул (хүснэгт 1), санхүүгийн хүнд байдалтай, өнөөг хүртэл газрын байгалийн хайгуул хийж, ашиглахад их хэмжээний мөнгө, хөрөнгө оруулалт хийж чадахгүй байна. Олборлоогүй асар арвин нөөц болон дотоодын эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс ангижирч чадаагүй байдлаа харгалзан, Монгол улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татах, олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн стратегиа сэргээхээр боллоо.

Монгол улс Азийн 48 орон, дэлхийн 195 орны дотор эзлэх байр

	Улсын ерөнхий хүчин чадал	Газар нутаг	Хүн ам	Эдийн засгийн бодит хүчин зүйл	Нэг хүнд ноогдох эдийн засгийн хүчин чадал
Ази	38	7	38	44	41
Дэлхий	117	20	92	151	184

Эх сурвалж: "Дэлхийн улс орнуудын нийт хүчин чадлын жагсаалт", Хятадын эдийн засгийн хэвлэлийн хороо. 1998, Бээжин.

1997 оны 6-р сар, 1998 оны 6-р сард Монголын Засгийн газар, Дэлхийн банк хамтран Улаанбаатар хотноо 2 удаа олон улсын хөрөнгө оруулагчдын хурал хийж, АНУ, Канад, Англи, ОХУ, Япон, Хятад зэрэг 24 улс, бүс нутгийн зуу гаруй гадаад худалдааны компани, Монголын хэдэн арван компани, арван хэдэн олон улсын байгууллагын төлөөлөгчид хуралд оролцож, Монголын Засгийн газрыг уул уурхайн баялгийг нээж ашиглахад гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хамтын ажиллагаанд оруулах болов. 1997 оны 6-р сард Монгол Улсын их хурлаас "Ашигт малтмалын хууль" шинээр баталж, гадаадын хөрөнгө оруулагчдад нэлээд их давуу тааламжтай нөхцөл олголоо. Уг хуулинд тогтоосноор гадаадын бизнесүүд уурхай нээх лиценз авахад Монголын аж ахуйн нэгжтэй адил нөхцөл олгосон ба хайгуул хийх хугацаа 3 жил ба 2 жилээр сунгаж болно. Ашиглах хугацааг 60 жил ба 40 жилээр сунгаж болно (нэг зуун жил ашиглаж болно). Улмаар өмчийн компанийн өмчлөх татвараас чөлөөлөх ба худалдааны орлого л авна.

Одоо Америк, Канад, Англи, Франц, Австрали, Орос, Япон зэрэг орон Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулах ихээхэн сонирхолтой байна.

Монголын нээлттэй бодлогыг дагалдан одоо нийт 62 улс, бүс нутгийн, 1500 гадаадын бие даасан (дангаар) ба хамтарсан үйлдвэр аж ахуйн газар (түүний дотор бие даасан 454) байгаа ба Монголд бүртгэж, бүртгэлийн бэлэн мөнгө 342 сая ам.доллар⁶. ("Мэнгу сяосибо" Монголын мэдээ, 2000.11.7) Зөвхөн 1998 онд шинээр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн газар 270-аар нэмэгдэж, түүний бүртгэлийн мөнгө 32 сая ам.доллар боллоо.

Тав. Хятад Монголын эдийн засаг, худалдааны үр ашигтай хамтын ажиллагаа

Нээлттэй бодлого гүнзгийрэх тусам, Хятад улс олон улсын хамтын ажиллагаанд оролцох, хоёр талын ба олон талын хамтын ажиллагааны тууштай алхам хийв. Гэвч ойрын хөрш Монгол улстай, 2000 оны 4, 6-р сард суурийг нь тавьсан Төмөртэйн овооны хар тугалга, цайрын уурхай ба Налайхын нефть боловсруулах үйлдвэрээс гадна, харьцангуй том хэмжээний хөрөнгө оруулалттай объект байхгүй байна. Хэдийгээр Хятад улс Монголд хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ олон орны дотор тэргүүнд яваа, өөрөөр хэлбэл 512 үйлдвэр аж ахуйн газарт нийт 76,9 сая ам.долларын⁷ хөрөнгө оруулалт хийсэн (2000 оны 10-р сарын эцэс гэхэд) боловч ихэнхи хэсэг нь мал аж ахуйн бүтээгдэхүүн, барилгын засал, хүнс, модон эдлэл, оёдлын үйлдвэрийг гол болгосон дунд, жижиг хэлбэрийн объект ба хувийн аж ахуй нь эдийн засгийн хүч сул, үр дүн багатай байна. Энэ нь Хятад, Монголын харилцааны өнөөгийн байдал, хоёр орны хамтын ажиллагааны нөөц боломжууд тэнцэхгүй байна. Үнэхээр ч Хятад улсын Монголтой хийж буй худалдааны хэмжээ их байх арга алга, учир нь Монголын хүн ам цөөн (1999 оны 12-р сарын байдлаар 2 сая 382 мянга 500 хүн амтай юм), зах зээлийн багтаамж хязгаарлагдмал, одоогийн хийж буй хоёр талын худалдааны арга хэлбэр ба бүтцээр, яагаад ч болов Хятадын гадаад худалдааны хэмжээ, үр ашигт нөлөөлөх буюу хэрэгцээг хангах бололцоогүй юм. Гэхдээ Хятад, Монголын хоёр талын бодит хэрэгцээ, алс хэтийн эрх ашгаас харах юм бол Монголын уул уурхайн баялагийг хамтран хөгжүүлэх нь үндсэндээ хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн үр ашигтай зам мөн.

Монголын талын эрчим хүчний хэрэгцээг харвал, хэтийн төлөв нь тийм ч сайнгүй байна. Монголын "Өнөөдөр" сонины (2000.11.8) мэдээлснээр, Монголын хамгийн том цахилгаан станц Улаанбаатарын 4-р цахилгаан станцын ашиглалтын хугацаа дөнгөж 10 жил үлдээд байгаа ба нийгэм-эдийн засгийн хөгжилтэй уялдуулах юм бол түүний хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж 75 тэрбум долларт хүргэх хэрэгтэй юм. Улаанбаатарын 2, 3-р цахилгаан станц ба Дархан, Эрдэнэт хоёр хотын цахилгаан станцын ашиглалтын хугацаа 2010-2015 он хүрэх ба хэрвээ эдгээр үйлдвэрийг засаж өргөтгөнө гэвэл 5,1 тэрбум ам.доллар шаардагдана. Монголын холбогдох мэргэжилтэнүүд тус улсын ураны нөөц ихтэй бодит байдлыг харгалзан атомын цахилгаан станц, нүүрсний хий боловсруулах үйлдвэр байгуулах санал дэвшүүлж байна. Энэ зоригтой төсөл хэрэгжихгүй зүйл ч биш юм. Одоо дэлхий дээр газар сайгүй цөмийн эрчим хүчний давуу талыг мэдэж, Хятад улс энэ талаар нэлээд алхам хийж, хэд хэдэн атомын цахилгаан станц байгуулсан туршлагатай тул Монголын талтай хамтарч ажиллахыг харгалзан үзэж болох юм. Нүүрсний хийг Хятадад газар сайгүй маш их хэрэглэж байгаа тул Монгол улс нүүрсний их нөөцөө ашиглаж, нүүрсний хий боловсруулах үйлдвэр байгуулж бүрэн болно. Нүүрсний хий бол хөнгөн хялбар, цэвэр, бохирдол багатай харьцангуй сайн түлш юм.

Мэдээж Хятадын болон олон улсын хамтын ажиллагааны хөрөнгийн хэмжээ Америк зэрэг хөгжингүй орных шиг зузаан биш боловч Монголд уул уурхайн баялагаа

ашиглахад нь хөрөнгө оруулах талаар Хятадад нэлээд их, иж бүрэн давуу тал байгаа юм. Өөрөөр хэлбэл уул усаар холбогдсон газар зүйн давуу тал, адил төстэй соёл, сэтгэлзүй, ялангуяа эдийн засгийн хөгжил дээр харилцан нөхөж, харилцан ашигтай хийгээд Хятадын уул уурхайн салбарт ашигладаг техник, тоног төхөөрөмж, удирдлагын туршлага ба дэлхий дээрх хамгийн элбэг ажиллах хүчний нөөц зэрэг нөхцөл бол бусад улсад амар хялбар бус юм. Хятад улс нөхцөл, бололцоотой тул Монголтой хамтран ажиллах, олон улсын өрсөлдөөнд идэвхитэй оролцох Монголд уул уурхайн салбарт хөрөнгө оруулж чухал үүрэг гүйцэтгэх эрмэлзлэл байгаа юм. Монгол нефтийн үйлдвэрээ хөгжүүлэх арга алхамын дагуу ч хүрэлцэхүйц хөрөнгө ба тоног төхөөрөмжийг бүрэлдүүлсэн үед Хятад улс нефть нэрэх үйлдвэр байгуулахад хойшдоо оролцож, туслаж болно. Энэ нь Монголд бүтээгдэхүүний нэмэлт өртгийг өсгөж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой нь эргэлзээгүй. Энэ нь Монголын урт хугацааны эрх ашгийг баталгаатай болгох, Хятад, Монголын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулахын тулд юм. Түүнчлэн цэцэглэн хөгжиж буй, тогтвортой Монгол улс нь Хятадад ашигтай, бүс нутагт ч ашигтай байх болно. Хятад улс Монголын уул уурхайн баялагийг нээж ашиглахад оролцох нь өнөөгийн Хятад, Монголын хооронд арьс, ноосоор гол болгосон жижиг хэлбэрийн богино хугацааны арилжааг ихээр өргөжүүлж, улмаар XXI зуунд чиглэсэн урт хугацааны, тогтвортой, эрүүл, харилцан хөнгөлөлттэй, Хятад-Монголын хөршийн найрсаг хамтын ажиллагааны харилцааг бататган хөгжүүлэхэд чухал урагшлуулагч ач холбогдолтой гэж үзэж болно.

Ер нь, Хятад, Монгол хоёр орон хамтран ажиллаж Монголын уул уурхайн баялгийг хөгжүүлэн ашиглах нь хоёр талын эрэлт шаардлага болох бөгөөд хоёр талын ашиг сонирхолын нийтлэг чанар болон эрэлтээ харилцан хангах чанартайгаараа алс хэтийн хөгжлийн төлөвтэй гэдгийг тогтоож, XXI зууны Хятад, Монголын эдийн засаг худалдааны харилцааны гол чиглүүлэг болох юм.

Зүүлт

- ¹ Монгол улс "Өнөөдөр" сонин, 2000.11.16
- ² Монгол улс "Өдрийн сонин", 2000.11.04
- ³ Хятад улс "Жэньминь жибао", 1997.05.12
- ⁴ Монгол улс "Засгийн газрын мэдээ", 1998.05.20
- ⁵ Хятад улс "Жэньминь жибао", 2000.11.02
- ⁶ Монгол улс "Мэнгү сяосибо" Монголын Мэдээ, 2000.11.07
- ⁷ Монгол улс "Мэнгү сяосибо" Монголын Мэдээ, 2000.11.07

Ашигласан материал

1. Монгол улс: "1999 оны Монгол Улсын статистикийн лавлах" УБ., 2000.
2. Хятад улс: Цянь Куо "Байгалийн баялагийн үйлдвэрийн удирдлага" Эдийн засгийн удирдлагын хэвлэлийн хороо, 1996, Бээжин.
3. Пунсалмаагийн Очирбат: "Үнэт эрдсийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи (алт, мөнгө, алмаз). Улаанбаатар 1999.